


A decorative graphic consisting of three blue spheres of different sizes (large, medium, and small) arranged diagonally from the top right towards the bottom left. Thin blue lines extend from the top left and top right corners, meeting at the small sphere in the middle.

“Сонгино” Бие Даан Амьдрах Төв

Мониторингийн тайлан

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18-д заасан Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, түүн дотор Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээний талаар тусгасан 18.1.6 заалтын хэрэгжилтэд хийсэн мониторингийн тайлан

М.Чулуун-Эрдэнэ, Ж.Энхтайван
8/1/2015

1. Мониторингийн үндэслэл

Манай улсын халамжийн тогтолцоо нь эмнэлгийн загварт суурилсан байдаг. Үүнээс үүдэн байнгын туслалцаа шаардлагатай хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог орхигдуулж гэр бүлд нь даатгах нь нийтлэг үзэгдэл. Энэ нөхцөлд ихэвчлэн тухайн өрхийн нэг гишүүн нь ажил эрхлэх боломжгүй болж, улмаар хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй айл ядууралд өртөх нэг шалтгаан болж байна. Үүнийг хүний эрхийг зөрчсөн үйлдэл гэж үзэх боломжтой.

Нөгөө талаар хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэр дундаа хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээ шаардлагыг оновчтойгоор тодорхойлсон бодлого, эрх зүйн орчин дутмаг байна. Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүн өдөр тутмын амьдралдаа хэн нэгний тусламж дэмжлэгийг байнга авах шаардлагатай байдаг. Манай орны хувьд ийм төрлийн үйлчилгээг Нийгмийн халамжийн тухай хуулиар зохицуулж бий болгосон ба тухайлбал, хуулийн 18-р зүйлд заасан Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, түүн дотор Гэрийн асрамж халамжийн үйлчилгээний тухай тусгасан 18.1.6-р заалтыг дурдаж болно. Хуульд тусгасан энэ үйлчилгээ нь 2006 оноос хойш хэрэгжиж эхэлсэн боловч хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд оролцох, бие даан амьдрах хэрэгцээг нь хангаж чадахгүй байна. Иймд энэ төрлийн үйлчилгээг цаашид хэрхэн сайжруулах арга, бололцоо байгааг тодруулах зорилгоор энэхүү мониторинг хэрэгжүүлээ.

2. Мониторингийн товч танилцуулга

Мониторингийн зорилго:

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.1.6-д заасан Гэрийн асрамж халамжийн үйлчилгээ гэрийн асрамж, халамжийн үйлчилгээ зайлшгүй шаарддаг зорилтот бүлэгтээ хэрхэн хүрч байгааг судалгаанд үндэслэн тодруулах, цаашид хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэнд туслалцаа үзүүлэх системийг боловсронгуй болгоход мониторингийн зорилго оршино.

Мониторингийн зорилт:

Гэрийн асрамж халамжийн үйлчилгээ нь хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэхийг судлах, үүнд тухайлбал олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг үзүүлдэг байгууллагуудыг хэрхэн сонгон шалгаруулж буй, тэдний үзүүлж буй үйлчилгээ хэр хүртээмжтэй байгаа талаар судалж тодруулах, мониторингийн дүнд үндэслэн тодорхой нөлөөллийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх зорилт тавин ажиллаа.

Хамрах хүрээ болон хугацаа байршил:

Мониторингийн нийт хугацаа 24 долоо хоног буюу 6 сарын хугацаанд Улаанбаатар хотын Баянзүрх, Хан-Уул дүүрэг, хөдөө орон нутгаас Өмнөговь аймгийг сонгон авч харьцуулсан байдлаар судалгаа хийв.

Хууль эрх зүйн орчин:

Монгол Улс ХБХЭК-д 2009 онд 56 дахь орон болон нэгдэн оржээ. Конвенцийн нийтлэг зарчим нь ХБХ-ний оролцоо, сонголттойгоор тэдний бие даасан байдлыг оролцуулан хувийн хараат бус байдлыг хүндэтгэх тухай заасан байдаг. Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст гэр болон оршин суугаа газрын болон тухайн оршин суугаа бусад орчны үйлчилгээ, түүний дотор амьдрахад нь дэмжлэг болохуйц болон тухайн оршин суугаа орчиндоо оролцоход нь хувийн туслалцаа хүртэх боломжтой байх бөгөөд нийгмээс тусгаарлах, хөндийрүүлэхээс хамгаалагдана хэмээн заасан байдаг.

Эдгээр зарчим нь Монгол улсын Нийгмийн халамжийн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль болон дагалдан гарсан тушаал тогтоомжид хангалтга сууж баталгаажаагүй байна. Тухайлбал, Монгол улсын хууль, тогтоол, тушаал, журамд ХБХ-ийн оролцооны тухай ямар ч заалт байхгүй байгаа нь

Төслийн нэр:
Төсөл хэрэгжүүлэгч байгууллага

дотоодын хууль тогтоомжийг ОУ-ын гэрээ конвенцид нийцүүлэх шаардлага байгааг харуулж байна.

Мониторингийн арга зүй, аргачлал:


Мониторингийн ажлыг гүйцэтгэхдээ дараах аргуудыг ашиглан мэдээлэл цуглууллаа

➤ Баримт бичиг судлах

Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээтэй холбоотой хууль эрх зүйн акт, түүнийг дагалдан гарсан дүрэм журмыг цуглуулж дүн шинжилгээ хийв.

➤ Анкетын арга:

Сонгон авсан тухайн аймаг дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс Нийгмийн халамжийн тухай хуулийн 18-р зүйлд тусан олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний талаар болон 18.1.6-д заасан Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамрагдаж байсан эсэхийг тодруулах, хамрагдаж байсан бол хэрэгцээ шаардлагад нь нийцэж байсан эсэхийг санал асуулга буюу анкетын аргаар судалсан. Судалгаанд нийт 84 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдсан ба насны ангилалаар нь авч үзвэл 45 % хувь 15-35 нас, 48 % хувь нь 35-55 нас, 55-дээш насны иргэд 7% хувийг эзэлж байна.



➤ Фокус бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын арга


Сонгосон аймаг дүүрэг тус бүрд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй таван иргэнийг сонгон авч, гэрт нь очиж, ярилцсан. Түүнчлэн мониторингийн хүрээнд сонгон авсан Аймаг Дүүргийн Нийгмийн Халамж, Үйлчилгээний Хэлтсийн Олон Нийтийн Оролцоонд Түшиглэсэн Халамжийн Үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн болон хороо хариуцсан халамжийн мэргэжилтнүүдтэй ганцаарчилсан болон бүлгийн ярилцла хийсэн.

3. Мониторингийн дүн


3.1 Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээний талаар ойлголт, мэдээлэл дутмаг байна.

Мониторингийн хүрээнд нийт 84 хөгжлийн бэрхшээлтэй иргэнээс судалгаа авч нэгтгэж үзэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэд (ХБИ) Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээний талаар ойлголт мэдээлэл дутмаг, сэргээн засах үйлчилгээ болон гэрийн асрамж, халамжийн үйлчилгээний ялгааг зааглаж мэдэхгүй байгаа нь харагдаж байна. Бодлого хэрэгжүүлэгчид Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээг уламжлалт аргаар сэргээн засах үйлчилгээтэй хамтад нь явуулах журмыг баталсан байгаа нь үүнд нөлөөлж байна.

Тухайлбал, Олон Нийтийн Оролцоонд Түшиглэсэн Гэрийн Асрамж, Халамжийн Үйлчилгээний талаар та хэр мэдэх вэ? гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 61 хувь нь мэдэхгүй, 39 хувь нь мэднэ гэж хариулсан байна.



Гэрийн асрамж халамжийн үйлчилгээнд та хамрагдаж байсан уу? гэсэн асуултанд санал асуулгад оролцогчдын 73 хувь нь үгүй гэсэн бол, 27 хувь нь хамрагдсан гэсэн хариултыг өгчээ.



Кейс судалгааны явцад ч энэ байдал түгээмэл ажиглагдсан ба өөрсдөд нь чухал хэрэгцээтэй ийм үйлчилгээ байдаг талаар ХБИ огт мэдээлэлгүй байв.

Кэйс 1: Хан-Уул дүүргийн 2-р хорооны иргэн У 51 настай, эмэгтэй. Хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй, орон сууцны 4 давхарт ээж, дүүгийн хамт амьдардаг. Ээж нь өндөр настай учир тэр бүр туслаад байж чаддаггүй. Дүү нь ажил хийдэг ч, өглөө гараад орой ирдэг. Иргэн У нь дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөвлөлийн даргын ажлыг хашихын зэрэгцээ дүүргийн Тамгын газарт нэг цэгийн үйлчилгээнд ажлын өдрүүдэд тогтмол суудаг ажилтай. Тэрээр “Надад хамгийн их тулгардаг бэрхшээл нь гэртээ орох, гарах асуудал үнэхээр толгойн өвчин болж байна. Манайх 4 давхарт байдаг учир буулгах хүн байдаггүй. Эхлээд 1950-аас такси дуудлага өгөөд буучихдаг байсан, сүүлдээ таксины жолооч нар дээш, доош гаргахаас төвөгшөөн, дуудлагын газрын такси үйлчилгээний газрууд манай хаягийг мэддэг болсноор дуудлагын такси ирэхээ больсон” гэлээ. Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээний талаар асуухад, “Тийм үйлчилгээ мэдэхгүй, байдаг бол хэрэгтэй л байна. Сэргээн засах үйлчилгээнд хамрагдаж байсан гэртээ бариулахдаа гол нь биш, хүн гуйлгүй гарч орох, чадахгүй зүйлдээ туслалцаа авмаар байна” гэсэн юм.

Кэйс 2: Өмнөговь аймгийн иргэн 3 нь 30 настай, эмэгтэй. Нуруу нугасны гэмтэл аваад 5 жил болж байна. Сүүлийн 5 жил гэрээсээ гарах нь битгий хэл, тэргэнцэр дээр сууж үзээгүй. Түүнд өдөр тутам туслах хүн байдаггүй учир хэн нэгэнд төвөг удахаас төвөгшөөн 5 жил орондоо хэвтэж байгаа. Тэрбээр дээд боловсролтой, автын инженер мэргэжилтэй бөгөөд мэргэжлээрээ нэг жил ажиллаад гэмтэл авсан. Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээний талаар ямар ч мэдээлэл байхгүй байлаа.


Дээрх бодит жишээнүүдээс харахад хүнд хэлбэрийн ХБИ-дэд хэрэгцээнд нь нийцсэн тусламж үйлчилгээ үнэхээр дутагдаж байгаа нь тодорхой байна. Хүнд хэлбэрийн ХБИ өөрсдөд нь чиглэсэн гэрийн асрамж халамжийн үйлчилгээ байдаг гэж мэдэхгүй учраас ямар нэг байдлаар эрх нь зөрчигдөж байна гэж боддоггүй. Гэтэл бодит байдалд өөрсдийнх нь эрх зөрчигдөөд зогсохгүй давхар гэр бүлийнх нь хүмүүсийн эрх давхар зөрчигдөх нь олонтаа тохиож байна.

Кэйс 3: Баянзүрх дүүргийн 22-р хорооны иргэн С нь 52 настай, эмэгтэй. Хүзүүний гэмтэлтэй. Хүүхдүүд нь тусдаа гарсан. Одоо бага хүүтэйгээ хамт амьдардаг. Бага хүү О нь оюутан болоод хэсэг хугацаанд хичээлдээ явсан ч, ээжийг нь харж хандах хүнгүй учир аргагүйн эрхэнд сургуулиа орхиход хүрсэн. Ээж нь хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй учир хувцсаа өмсөх, хоол унд идэх гээд хүний наад захын өдөр тутмын хэрэгцээт зүйлээ өөрөө хийж чадахгүй учир хүүгээ сургуулиас нь гаргахаас өөр замгүй болсон тухай ярьж байлаа. Мөн “Надад ямар нэг чиглэлийн нийгмийн хамгааллын тэр тусмаа туслах үйлчилгээ үнэхээр хэрэгтэй байдаг. Хэрэв тийм үйлчилгээ байдаг бол би хүүгээ сургуульд явуулалгүй яахав нэг ёсондоо би хүүгээ өөрийнхөө төлөө золиос болгож

байна” гэсэн юм. Иргэн С нь Гэрийн асрамж халамжийн үйлчилгээний тухай сонсож байгаагүй, мэдэх ч үгүй гэж ярих.

3.2 Гэрийн асрамж халамжийн үйлчилгээ ХБИ-ийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байна

Мониторингийн судалгаанд хамрагдсан ХБИ-ээс Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээ таны хэрэгцээ шаардлагад хэр нийцэж байна вэ? гэж асуухад дараах хариултыг өгсөн байна.



Дээрх дүнгээс үзэхэд гэрийн асрамж халамжийн үйлчилгээнд ихэнх нь хамрагдаж чадахгүй байгаагаар зогсохгүй, хамрагдаж чадсан ч уг үйлчилгээ хэрэгцээнд нь төдийлэн нийцэж чадахгүй байгаа нь тодорхой байна. Энэ нь 3 гол шалтгаантай байгаа нь судалгааны явцад тодорхой болов. Үүнд:

1. Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээг уламжлалт аргаар сэргээн засах үйлчилгээтэй хамтад хүргэхээр журамласантай холбоотой дээрх 2 үйлчилгээний ялгаа зааг нь ойлгомжгүй болсон,
2. ХБИ-ийг бэрхшээлийн төрлөөр нь ангилсан ангилал байхгүйгээс зорилтот бүлэг буюу хүнд хэлбэрийн ХБИ үйлчилгээнд хамрагдаж чадахгүй үлддэг,
3. Уг үйлчилгээг өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд жилд нэг удаа 15 хоног авч болохоор журамд заасан байгаа нь өдөр тутам туслалцаа шаардлагатай ХБИ-ийн хэрэгцээнд нийцэхгүй байгаад зогсохгүй эрхийг нь ноцтой зөрчиж байна.

Баянзүрх дүүрэгт Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг 11 байгууллага гүйцэтгэж байгаагаас 2 байгууллага нь Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээг гүйцэтгэж байна. Гэхдээ гэрийн асрамж, үйлчилгээг уламжлалт аргаар сэргээн засах, үйлчилгээтэй хамт нь хэрэгжүүлдэг. Уламжлалт аргаар сэргээн засах үйлчилгээ,

гэрийн асрамж, халамжийн үйлчилгээтэй хамтад нь явуулж байгаагаас гэрийн асрамж, үйлчилгээ нь орхигдож сэргээн засах үйлчилгээ нь түлхүү явж байгаа нь судалгааны явцад ажиглагдсан. Энэ тухай судалгаанд хамрагдсан халамжийн ажилтнуудаас тодруулж асуухад: “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс энэ талаар санал хүсэлт гаргадаггүй тэгэхээр хэрэгцээнд нийцэж байгаа гэж үзэж болно. Гэхдээ гэрийн асрамж, халамжийн үйлчилгээ ихэвчлэн дангаараа биш уламжлалт аргаар сэргээх, засах үйлчилгээтэй хамт явагддаг болохоор хүмүүс ялгаж салгаж ойлгохгүй байх шиг байдаг. Жнь: хумс авах гэр орныг нь цэвэрлэх үйлчилгээ хэрэгтэй хүндээ хэрэгтэй. Гэтэл хумсаа авхуулах, гэрээ цэвэрлүүлэх шаардлагагүй хүмүүс авах эрх үүсээд байдаг нь буруу юм шиг санагддаг” гэж ярьж байлаа. /ХУД-ын халамжийн ажилчдын ярианаас/

Судалгааны дүнгээс харахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тодорхой хэсэг нь гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа ч ХБИ-ийг бэрхшээлийн төрлөөр нь ангилсан ангилал байхгүйгээс яг зорилтот бүлгийн хүнд хэлбэрийн ХБИ үйлчилгээнд хамрагдаж чадахгүй үлдээд байгаа нь тодорхой харагдаж байна. Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээг зохицуулж байгаа дүрэм журмын дагуу уг үйлчилгээг өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд жилд нэг удаа 15 хоног үйлчилгээнд хамрагдахаар заасан байгаа. Гэтэл өдөр тутам бусдын дэмжлэг тусалцаа шаардлагатай ХБИ-ийн хувьд 15 хоног хангалтгүй болох нь ойлгомжтой.

Сунгах хэрэгтэй юм шиг харагддаг. Гэртээ ганцаараа амьдардаг өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байдаг. Гэхдээ хүнд хэлбэрийн байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэд бол өдөр тутам хүний тусламж дэмжлэг хэрэгтэй байдаг хүмүүст 15 хоногийн хугацаа бол богино юм. Тийм учраас сунгах хэрэгтэй гэдэгтэй санал нийлж байна. /БЗД-ын халамжийн ажилчдын ярианаас/

3.3 Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах үйл ажиллагаа ил тод биш

Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулахдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангахгүй, ил тод биш байгаа нь бидний судалгаанаас харагдаж байна. Энэ үйлчилгээг сонгон шалгаруулах, тендерийн бичиг баримтын шалгуур үзүүлт нь сүүлийн 5 жил ажилласан туршлагатай байх, голлон ажиллах хүмүүс нь эмч эмнэлгийн ажилтнууд байхаар заасан байдаг. Ийм нөхцөлд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд гэрийн асрамж, халамжийн үйлчилгээг үзүүлэх боломжгүй болж байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.5-д заасанчлан Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэх байгууллагыг сонгон шалгаруулах ажлыг Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний байгууллага нь иргэн,

аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгэж болно гэсэн байдаг. Гэтэл энэ хуулийн дагуу тухайн дүүрэг, аймгийн Нийгмийн Халамж Үйлчилгээний хэлтсээр сонгон шалгаруулалт хийлгэлгүй Нийгмийн Халамж, Үйлчилгээний Ерөнхий Газар нь 2006 оноос хойш Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах ажлыг хийж байгаа нь бидний судалгааны явцад тодорхой болсон. Ингэж хууль зөрчин үйлчилгээ үзүүлэх байгууллагуудыг сонгон шалгаруулж байсантай нь холбогдуулан Нийгмийн Халамж Үйлчилгээний Ерөнхий Газрын удирдах албан тушаалтнууд Цагдаагийн Ерөнхий Газрын Гэмт хэрэгтэй тэмцэх газарт шалгагдах болсон. Энэ асуудал үүссэний дараа 2015 оноос хуульд заасанчлан Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс сонгон шалгаруулалтыг зарлан явуулахаар шийдвэрлэсэн ч оны төгсгөл дөхөж байхад сонгон шалгаруулалтыг эхлүүлээгүй байна. Бид хуульд заасан үйлчилгээ яагаад урагшлахгүй байгаа талаар Нийслэлийн Нийгмийн халамж, үйлчилгээний газрын удирдлагууд болон Хүн амын хөгжил нийгмийн хамгааллын сайдад асуулт тавин албан тоот илгээсэн ба тэдний зүгээс уг үйлчилгээг урагшлуулах болно гэсэн тодорхойгүй хариу ирүүлсэн.

Дүгнэлт 1

1. Нийгмийн халамжийн тухай 18-р зүйлийн 18.1.6 заасан Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээний тухай хөгжлийн бэрхшээлтэй иргэд тэр бүр мэдэхгүй байгаа нь бидний судалгаагаар харагдаж байна. Мэдээлэлгүй болохоор үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байна.
2. Нөгөө талаар ийм үйлчилгээ байгаа гэж мэдэхгүй учраас өөрийнхөн эрх зөрчигдөж байна гэж боддоггүй. Гэтэл өөрийнх нь эрх зөрчигдөөд зогсохгүй давхар гэр бүлийнх нь хүмүүсийн эрх зөрчигдөж байгаа нь түгээмэл байна.
3. Төрийн үйлчилгээний ажилтнууд хуулийг сурталчлах талаар ажиллахгүй байна.

Дүгнэлт 2

1. Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд өнөөдрийн хэрэгжиж байгаа хууль тогтоомжийн хүрээнд эрэгтэй 60 хүрсэн, эмэгтэй 55 хүрсэн, хөдөлмөр магадлах комиссын хурлаар орж хөгжлийн бэрхшээлтэй нь тогтоогдсон бүх хөгжлийн бэрхшээлтэй иргэд хамрагдахаар заасан байгаа нь халамжийг хэтэрхий хавтгайруулсан гэж үзэх үндэслэлтэй байна.
2. Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээг уламжлалт аргаар сэргээн засах үйлчилгээтэй хамтад нь явуулж байгаагаас иргэд, мөн хороод хариуцсан халамжийн ажилчид хүртэл уг 2 үйлчилгээний ялгаа заагийг ялгаж, салгаж ойлгож чадахгүй байна.
3. Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээг Нийгмийн Халамж Үйлчилгээний Ерөнхий Газраас батлан гаргасан журамд жилд нэг удаа л ажлын 15 хоногийн хугацаанд үйлчилгээ авч болохоор заасан байгаа нь оновчгүй байна гэж бид үзэж байна. Үүнээс болж хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс 15 хоног үйлчилгээнд хамрагдаад бусад үедээ гэрийн бүлийн хэн нэгний хараат байдал амьдархад хүргэж байна.
4. Хүний өдөр тутмын энгийн хэрэглээ болох хувцсаа өмсөх, хоол унд идэх, бие засах гэх мэт үйлдлээ бие даан гүйцэтгэх чадахгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангаж чадахгүй байна. Тийм учир эдгээр иргэд нийгэмд оролцох боломжгүй, гэр бүлийнхээ хэн нэгний гарыг харсан, гэрийн хорионд амьдрахад хүргэж байна.

4.Зөвлөмж

Хүн Амын Хөгжил Нийгмийн Хамгааллын Яамны Хөгжлийн Бэрхшээлтэй Иргэдийн Хөгжлийн Хэлтэст

- Нийгмийн Халамжийн Тухай 18-р зүйл Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний 18.1.6 заасан Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээг илүү боловсронгуй болгоход олон улсын сайн жишгийг нэвтрүүлэх, нутагшуулах ажлыг эхлүүлэх
- Одоогийн хэрэгжиж байгаа халамжийн тогтолцоо эмнэлэгийн загвар дээр суурилсан байгааг өөрчилж хүний эрх дээр суурилсан үйлчилгээг бий болгох
- Жилд нэг удаа 15 хоног үйлчилгээ авдаг явдлыг өөрчилж зорилтот бүлгийг оновчтой тодорхойлж тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээг хүн бүрт харилцан адилгүй хүргэх.
- Үйлчилгээг тухайн хүний хэрэгцээнд нийцүүлэн тогтоох
- Үйлчилгээ зайлшгүй шаардлагатай хүнд үзүүлэх гэрийн асрамж халамжийн үйлчилгээг жилийн турш тасралтгүй хүргэх
- Үйлчилгээг нэр төрлөөр бус цагаар тогтоон хүргэдэг системийг боловсруулан хэрэгжүүлэх
- Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээг стандарттай болгох
- Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээг зохицуулж байгаа дүрэм журмыг боловсруулах, батлахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын төлөөллийг оролцуулах
- Энэ үйлчилгээг гүйцэтгэх байгууллага нь хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үүсэл санаачлагын байгууллага байхыг дэмжих

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хийсэн мониторинг үндэслэж энэхүү зөвлөмжийг боловсруулав.

Нийгмийн ХаламжҮйлчилгээний Ерөнхий Газарт

- Нийгмийн Халамжийн Тухай 18-р зүйл Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний 18.1.6 заасан Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээг илүү боловсронгуй болгоход олон улсын сайн жишгийг нэвтрүүлэх, нутагшуулах ажлыг эхлүүлэх
- Одоогийн хэрэгжиж байгаа халамжийн тогтолцоо эмнэлэгийн загвар дээр суурилсан байгааг өөрчилж хүний эрх дээр суурилсан үйлчилгээг бий болгох

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чадвар алдалтын ангилалыг зөв тогтоох нь цаашид хэн ямар үйлчилгээ авах нь тодорхой болж өгнө.
- Жилд нэг удаа 15 хоног үйлчилгээ авдаг явдлыг өөрчилж, зорилтот бүлгийг оновчтой тодорхойлж, тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээг хүн бүрт харилцан адилгүй хүргэх.
- Үйлчилгээг тухайн хүний хэрэгцээнд нийцүүлэн тогтоох
- Үйлчилгээ зайлшгүй шаардлагатай хүнд үзүүлэх гэрийн асрамж халамжийн үйлчилгээг жилийн турш тасралтгүй хүргэх
- Үйлчилгээг нэр төрлөөр бус цагаар тогтоон хүргэдэг системийг боловсруулан хэрэгжүүлэх
- Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээг стандарттай болгох
- Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээг зохицуулж байгаа дүрэм журмыг боловсруулах батлагдан гаргахад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын төлөөллийг оролцуулах
- Энэ үйлчилгээг гүйцэтгэх байгууллага нь хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үүсэл санаачилгын байгууллага байхыг дэмжих

Хавсралтууд

ХБХЭЖ-ийн 19 дүгээр зүйл

Бие даан амьдрах болон тухайн оршин суугаа орчиндоо байх эрх

Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй бүх хүний бусдын нэгэн адил ердийн оршин суугаа газартаа амьдрах тэгш эрхийг хүлээн зөвшөөрч, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс энэхүү эрхээ эдлэх явдлыг хангах, тухайн оршин суугаа орчиндоо бүрэн дүүрэн хамрагдаж оролцохыг дэмжих үүднээс дараах нөхцөлийг хангах замаар зохистой, үр дүнтэй арга хэмжээ авна:

а) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь бусдын нэгэн адил оршин суух газар болон хаана, хэнтэй амьдрах эсэхээ чөлөөтэй сонгох боломжтой байх ёстой бөгөөд тусгай нөхцөл байдалд амьдрахыг шаардахгүй;

б) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст гэрийн, оршин суугаа газрын болон тухайн оршин суугаа бусад орчны үйлчилгээ, түүний дотор амьдрахад нь дэмжлэг болохуйц болон тухайн оршин суугаа орчиндоо оролцоход нь хувийн туслалцаа хүртэх боломжтой байх бөгөөд нийгмээс тусгаарлах, хөндийрүүлэхээс хамгаалагдана;

с) нийт хүн амд үйлчлэх зориулалттай нийтийн үйлчилгээ, объект нь бусадтай адил тэгш байх үндсэн дээр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хувьд хэрэглэх боломжтой байх бөгөөд хэрэгцээнд нь нийцсэн байна.

Журам 1

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын тушаал

2012 оны 07 дугаар сарын 23-ны өдөр
Улаанбаатар хот

Дугаар 162

Журам, маягтын загвар батлах тухай

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.1.6, 13.2 дугаар зүйл Монгол улсын Засагийн газрын 185 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох журам”-ын 2.12 дугаар заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Гэрийн халамж, асрамжийн үйлчилгээний журмыг 1 дүгээр хавсралтаар, Гурав ба түүнээс дээш ихэр, хүүхдийг төрийн зардлаар өсгөж, хүмүүжүүлэх журмыг 2 дугаар хавсралтаар, “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийг асрах гэрээ”-ний зааварыг 4 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалт гарсан холбогдуулан Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 129, 69 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Батлагдсан журам, аргачлалыг орон нутагт хэрэгжүүлэх, маягтыг олшруулан үйл ажиллагаандаа хэрэглэх ажлыг зохион байгуулахыг аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга нарт зөвшөөрсүгэй.

4. Тушаалын биелэлтэнд хяналт тавиж ажиллахыг газрын Дэд дараг /Ж.Эрдэнэбаатар/ Хяналт, шинжлгээ, үнэлгээний хэлтэсийн дарга/М.Ариунжаргал/ нарт үүрэг болгосугай.

ДАРАГ

Д.БАЯРСАЙХАН

Журам № 2

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргаын 2012оны 162 тоот тушаалыг 1 дүгээр хавсралт

ГЭРИЙН АСРАМЖ, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

1. Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд, хамрагдаагүй, бие даан амьдрах чадваргүй, ганц бие, байнгын эмчилгээ асаргаа шаардагдах ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, Нийгмийн халамжийн тухай хуулын 18 дугаар зүйлд заасан, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний гэрийн халамж, асрамжийн үйлчилгээ авах тухай хүсэлтээ гаргавал аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагаас зохих төлбөртэй болон төлбөргүй үйлчилгээ үзүүлэхэд энэхүү журмыг баримтална.

2. Гэрийн халамж, асрамжийн дор дурдсан төрөлтэй байж болно.

- Гэр барих, цонх хаалаг угаах, дулаалах
- Хүнсний зүйл цуглуулах, хоол хийх хооллох
- цагаан хэрэглэл, хувцасыг угаалаг цэвэрлэгээнд хүргэж өгөх авч ирэх
- Агаар, нар салхинд гаргах, усанд оруулах, үс засуулах
- Эмнэлэгт үзүүлэх, эм тариаг эмийн сангаас авч өгөх, эмийн бус эмчилгээ үйлчилгээ үзүүлэх
- Сонин хэвлэл захиалах, шуудан, номын сангийн үйлчилгээ авахад нь туслах, үзвэр үзүүлэх, тоглоом тоглуулах
- Түлээ, нүүрс худалдан авах, мод хөрөөдөж хаглах
- Тохирсон хөдөлмөр эрхлэхэд нь дэмжилэг үзүүлэх
- Эрүүл мэнд, амьдрах ухааны зэрэг сургалт үйлчилгээнд хамруулах

3. Сум, хорооны нийгмийн ажилтан нь гэрийн халамж, асрамжийн төлбөртэй болон төлбөргүй үйлчилгээнд хамрагдах ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгааг гаргаж аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллагад хандан шийдвэрлүүлнэ.

4. Гэрийн халамж, асрамжийн үйлчилгээг үзүүлэхдээ төрийн бус байгууллага, сайн дурын идэвхтний өөрсдийнх нь хүсэлтээр гүйцэтгүүлж болно.

5. Төрийн бус байгууллага, сайн дурын идэвхтнээр гэрээгээр гүйцэтгүүлэх гэрийн асрамж, халамжийн үйлчилгээг сум, хорооны нийгмийн ажилтан, үйлчилүүлэгч, үйлчлэгч гэсэн гурвалсан гэрээ байгуулах ба үйлчилгээ үзүүлэх хугацаа, үйлчилгээний төрөлийг тогтоож, Засаг даргаар батлуулан ажиллана. Төрийн бус байгууллага, сайн дурын идэвхтэн байхгүй тохиолдолд ажил идэвхтэй эрэ байгаа бүртгэлтэй иргэдээс байнгын үйлчилэгч томилон ажиллуулж болно. Үйлчилэгчийн ажлын ачааллыг орон нутгийн онцлогоос шалтгаалан тогтоох бөгөөд сарын цалин, хөлс нь хөдөлмөрийн хөлсний доод хэжээнээс багагүй байна.

6. Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээний чанарт сум, хорооны нийгмийн ажилтан, үйлчилүүлэгч нар хамтран хяналт тавина.

7. Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээг чанаргүй гүйцэтгэсэн, үйлчилүүлэгчийн эрх ашгийг хохироосон тохиолдолд сум, хорооны нийгмийн ажилтан гэрээг зогсоох тухай эрх бүхий байгууллагад асуудлыг тавьж, холбогдох хууль тогтоомжуудын дагуу шийдвэрлүүлнэ.

Гэрийн асрамж, халамжийн төлбөргүй үйлчилгээ

8. Өөрөө өөртөө үйлчилэх чадваргүй, ядуу, нэн ядуу амьдралтай, ганц бие, гэрийн асрамж, халамжийн үйлчилгээ шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн хүсэлтээ гаргавал тэдэнд төлбөргүй үйлчилгээ үзүүлнэ.

9. Гэрийн асрамж, халамжийн төлбөргүй үйлчилгээнд хамруулахдаа тухай иргэний оршин суугаа баг, хорооны Засаг даргын тодорхойлолтыг үндэслэнэ.

10. Нэн ядуу амьдралтай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд төлбөргүй хамруулсан тохиолдолд үйлчлэгчийн сарын цалин, бусад холбогдох зардлыг Нийгмийн үйлчилгээний сангаас олгоно.

Гэрийн халамж, асрамжийн төлбөртэй үйлчилгээ

11. Орон байртай, ядуу бус боловч өөрөө өөртөө үйлчилэх чадваргүй ганц бие ахмад иастан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн гэрийн үйлчлэгч шаардлагатай тухай хүсэлтээ албан ёсоор тавьсан тохиолдолд тэдэнд төлбөртэй үйлчилгээг үзүүлж болно.

12. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн төрөлжсөн асрамжийн газар болон бусад халамж, асрамжийн төвд тодорхой хугацаанд байрлан асруулахаар бол ор хоногийн хөлсөнд хоолны үнэ болон бусад бүх төрлийн үйлчилгээний хөлс багтсан байна.

13. Асрамжийн газар болон бусад халамж, асрамжийн төв нь өөрсдийн үзүүлэх төлбөртэй үйлчилгээний төрөл тус бүрт тоирсон үнэ тарифыг тогтоон харьяалагдах аймаг, дүүрэг, сум, хорооны Засаг даргын тамгын газартай зөвшөлцөн баталж мөрдөнө.

14. Төлбөртэй үйлчилгээнд хамрагдах тухай хүсэлт гаргасан иргэнтэй сум, хорооны нийгмийн ажилтан, үйлчлэгч гурвалсан гэрээ байгуулан ажиллана. Гэрээнд үйлчилгээ үзүүлэх хугцаа, үйлчилгээний төрөл, төлбөрийн талаар тодорхой тусгагасан байна.

15. Гэрийн үйлчилгээ үзүүлэх гэрээг аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга, гүйцэтгэгч байгууллагатай хийж, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарын дарга батална.

Журам № 3

НИЙГМИЙН ХАЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.1.6 гэрийн асрамж, халамжийн үйлчилгээ

2013 оны 05-р сарын 23-ны өдрийн 143-тоот тушаал

Үйлчилгээний чиглэл:

1. Асаргаа эрүүл мэнд, гэр ахуйн, мэдээлэл хангах, гадуур ажилд туслах гэх мэт үйлчилгээ үзүүлэх

Үйлчилгээний хэлбэр:

1. Гэр ахуйн үйлчилгээ үзүүлэх
2. Өдөр тутамын асаргааны үйлчилгээ үзүүлэх
3. Гадуур ажилд туслах үйлчилгээ үзүүлэх
4. Эрүүл мэнд, эмчилгээний дэглэм сахиулах
5. Хоол хүнс бэлтгэх, хоолны дэглэм сахиулах, хооллож ундлах

Хамрагдах өрх, иргэн:

1. Байнгын асаргаатай ахмад настан.
2. Байнгын асаргаатай хөглжийн бэрхшээлтэй иргэн
3. Хүнд нөхцөлд байгаа хүүхэд: **(Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2012 оны А91 тоот тушаалын 2 дугаар хавсралтад зааснаар)**

Журам № 4

НИЙГМИЙН ХАЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 04-р сарын 20 өдөр

Дугаар 55

Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай

“Нийгмийн халамжийн тухай” хуулийн 18.7 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор тушаах нь:

1. “Үйлчилгээнд хамрагдах иргэний тоо, шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлох аргачлал, заавар”-ыг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан аргачлалыг орон нутагт хэрэгжүүлэх ажил зохион байгуулахыг аймаг, дүүргийг Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн дарга нарт зөвшөөрсүгэй.
3. Аргачлалыг хэрэгжүүлэх зөвлөмж, арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн халамж үйлчилгээний газрын дарга /М.Лхагвасүрэн/, бүртгэл, төлөвлөлтийн газар /Ч.Эрдэнэбулган/ нарт тус тус даалгасугай.
4. Энэ тушаал гарсантай холбогдуулан 2013 оны 05 дугаар сарын 23-ний өдрийн 143 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
5. Энэ тушаалыг 2014 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй

Дарга

Д.БАЯРСАЙХАН

Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах

Гэрийн асрамж, халамжийн үйлчилгээг иргэн, АНН, ТББ-аар гүйцэтгүүлэхэд олгох санхүүжилтийг тооцохдоо доорх үнийн тарифыг баримтлан, гүйцэтгэсэн үйлчилгээний зардлыг санхүүжүүлнэ.

Өөртөө үйлчлэх чадвар нь суларсан гэрийн асрамж, халамжийн үйлчилгээ шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд тухайн өдөрт үйлчилсэн гэрийн асрамж халамжийн үзүүлсэн тухай өдөр бүр тэмдэглэл хөтөлнө.

Гэрийн асрамж халамжийн үйлчилгээний зардлын хэмжээ /1 удаа/

Үзүүлсэн үйлчилгээний зардал гэдэгт доорх үйлчилгээний төрлийг гүйцэтгэсэн багц үйлчилгээг тооцож санхүүжилтыг олгоно.

№	Зардлын нэр	Үнийн дүн
1	Унааны зардал	7000
2	Цэвэрлэгээ үйлчилгээ	4000
3	Эрүүл мэндийн үйлчилгээ	9000
Бүгд		20.000

1. Унааны зардал:

- ✓ Тухайн иргэний гэрт очих буцах замын зардал

2. Цэвэрлэгээ, үйлчилгээ:

- ✓ Сум, хорооны нийгмийн ажилтан, СӨХ, өрхийн эмч хорооны засаг дарга зэрэгт өргөдөл хүсэлт гаргах, төрийн болон төрийн бус байгууллага зэрэг газраар үйлчлүүлэгчийг төлөөлж бичиг баримт бүрдүүлэх
- ✓ Усанд оруулах, хөл гарын хумс авах
- ✓ Халуун хүйтэн жин тавих
- ✓ Бие засуулах өтгөн шингэн цэвэрлэх
- ✓ Хоол цай хийх, аяга таваг угаах, хооллох
- ✓ Ор дэр засах хураах
- ✓ Хувцас цагаан хэрэглэл угаах солих
- ✓ Тоос арчих, шал угаах, цонхны тавцан ариутгал халдваргүйдлын бодисоор арчих
- ✓ Нүүрс савлах, гал түлэх

3. Эрүүл мэндийн үйлчилгээ:

- ✓ Нүүрс савлах, гал түлэх
- ✓ Амьдралын бэрхшээл, сэтгэл санааны хямрал өвчний зовиур шаналгааг даван гарахад туслах зорилгоор зовлонг нь сонсож харилцах ярилцах

- ✓ Өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл өгөх
- ✓ Эмчид үзүүлэхэд нь тусалж өргөж тээн эргүүлэн сэлгүүлж хэвтүүлэх
- ✓ Амьсгалын болон хөдөлгөөний эрхтнийг сэргээх дасгал хөдөлгөөн зааах

Дээрх үйлчилгээнүүдээс тухайн өдөрт аль тохирохыг нь гүйцэтгэнэ.

Гэрийн асрамж халамжийн үйлчилгээг уламжлалт сэргээн засах үйлчилгээтэй хамт үзүүлж болно. Уламжлалт аргаар үзүүлэх зарим үйлчилгээг гэр бүлийн гишүүд болон иргэд өөрөө бие даан хийж чаддаг болоход анхаарна. Гэсэн 3 багцад хувааж гэрийн асрамж, халамжийн үйлчилгээг Уламжлалт аргаар сэргээн засах үйлчилгээтэй хамтад нь хүргэж байх жишээтэй.